



# БАЯН СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## 2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248  
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан  
Аймгийн Ерөнхий аудитор  
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор  
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар  
Төрийн байгууллагын ордон

## Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

### АГУУЛГА

### ХУУДАС

|                                           |     |
|-------------------------------------------|-----|
| • Аудит хийж дууссан тухай мэдэгдэл ..... | 2-3 |
| • Танилцуулга .....                       | 4   |
| • Санхүүгийн дотоод хяналт .....          | 4-7 |
| • Гол шийдлүүд .....                      | 8   |
| • Тайлбар мэдүүлгийн захидал.....         | 8   |
| • Аудитын санал дүгнэлт .....             | 8   |

**Төв аймгийн Баян сумын төсвийн байгууллагууд,  
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд  
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баян сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баян сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:**

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:**

- Орон нутгийн орлогыг 28169.6 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 30921.6 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 2752.0 мянган төгрөгөөр буюу 109.8 хувиар давуулан биелүүлсэн байна.
- ЕБСургуулийн үйл ажиллагааны орлогоор нэгтгэсэн 3468.8 мянган төгрөгийг нэмэлт дансны санхүүжилтээр нэгтгэж залруулсан.
- Сумын нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн байгууллагаас 18500.0 мянган төгрөгний хандив авсан нь Монгол улсын “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17.1-д Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн

- Баян сумын ЕБСургууль мөнгөн хөрөнгө болон авлагын дансны хувьд хязгаарлалттай дүгнэлт авсан
- Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлээс 3 иргэний 9153.1 мянган төгрөгний зээл хугацаа хэтэрсэн байна
- Сумын ИТХурлын төсвийн шууд захирагчийн үүргийг ИТХурлын дарга гүйцэтгэсэн 2013 онд батлагдсан төсвийг 399.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн ИТХурлын хоолны зардалд зарцуулсан.
- Сумын ИТХурал нь 3 орон тоогоор ажилласан байгаа ба үүнд ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, жолооч гэсэн 3 орон тоотой ажилласан байгаа ба хурлын машин 2013 оны 9-р сараас эвдэрч зогссон байна
- Сумын Засаг дарга нь замын хуудас, маршрут бичилгүйгээр 4403.1 мянган төгрөгийн шатахуун олгох цохолт хийсэн байгаа нь Сумын Засаг дарга буюу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйл 14.2 төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаарх бүрэн эрх, 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах” гэсэн заалтуудыг зөрчин төсвийн шууд захирагчийн төсвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхэд нөлөөлсөн байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй

санал дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

## **ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

**2014.03.25**

## Танилцуулга

Баян сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

### Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баян сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Баян сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баян сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

### Орлого санхүүжилтийн талаар:

Баян сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 28169.6 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 30921.6 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 2752.0 мянган төгрөгөөр буюу 109.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 13138.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд орлогын 828064.2 мянган төгрөгийн, зарлагын 837635,7 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж жилийн эцэст 3567.3 мянган төгрөгийн үлдэгдэл орон нутгийн төсвийн 140200910 тоот дансанд байна. Орон нутгийн харилцах дансны ХААН банкинд байсан үлдэгдэл 611.7 мянган төгрөг аймгийн төсөвт төвлөрүүлснээр зөрүүтэй байсныг залруулсан.

Орлогыг нэр төрлөөр тоцоход:

Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 30921.6 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 244151.4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 743114.2 мянган төгрөг, ОНХСанд аймгийн төсвөөс 83676.0 мянган төгрөг, БХСанд 12000.0 мянган төгрөг, халамжийн санхүүжилт 155905.0 мянган төгрөг, ХЭДСангаас СХСанд 50000.0 мянган төгрөг нийт 1319768.2 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төрийн сангийн шилжүүлгээр санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 178022.1 мянган төгрөг, ИТХуралд 35541.6 мянган төгрөг, Багт 30587.7 мянган төгрөг нийт 244151.4 мянган төгрөгийн санхүүжилтийг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазар 39481.4 мянган төгрөгийг олгосон байна. БХСанд 12000.0 мянган төгрөг, ОНХСанд 83676.0 мянган төгрөг тус тус олгогдсон байна. 2013 оны жилийн эцсийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл ЗДТГазар 40163.7 мянган төгрөг, Баг 3843.5 мянган төгрөг бүгд 44007.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлснийг бууруулан нэгтгэсэн.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 376325.9 мянган төгрөг, Цэцэрлэгт 111151.4 мянган төгрөг, Эмнэлэгт 198393.0 мянган төгрөг, Соёлын төвд 57243.9 мянган төгрөг, нийт 743114.2 мянган төгрөг шилжүүлсэн ба дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 16136.4 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 155585.3 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 121139.6 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 28610.7 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 5150.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685.0 мянган төгрөг зарцуулсан байна. СТСХэлтсийн ирүүлсэн санхүүжилтээс  $155585.3 - 155905.3 = -320.0$  мянган төгрөг зөрүүтэй.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 3797.1 мянган төгрөг, Сургууль 12253.8 мянган төгрөг, ЭМТөв 2139.4 мянган төгрөг нийт 18190.3 мянган төгрөгийг орлого, 18190.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст үлдэгдэлгүй нэгтгэгдсэн. ЕБСургуулийн үйл ажиллагааны орлогоор нэгтгэсэн 3468.8 мянган төгрөгийг нэмэлт дансны санхүүжилтээр нэмж 15722.6 мянган төгрөгөөр нэгтгэж залруулсан.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 1120.0 мянган төгрөг ба татварын орлогоор төвлөрсөн өөрийн орлого 331.5 мянган төгрөг бүгд 1451.5 мянган төгрөг, Баг 261.0 Соёлын төв 957.7 мянган төгрөг, ЭМТөв 365.0 мянган төгрөг, Цэцэрлэг 198.0 нийт 3233.2 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

#### **Мөнгөн хөрөнгийн талаар:**

Сумын нэгтгэсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 4.5 мянган төгрөг, ИТХурал 3054.0 мянган төгрөг, Баг 437.1 мянган төгрөг, Сургууль 15.5 нийт 3511.1 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 101235.3 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 13138.8 мянган төгрөг, эм эргэлтийн сан 2859.9 мянган төгрөг нийт 120745.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 150682.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 3567.3 мянган төгрөг, эм эргэлтийн сан 2338.6 мянган төгрөг, ЕБСургууль 15.5 нийт 156604.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 102727.4 мянган төгрөгийн авлага, оны эцэст 181797.3 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 79069.9 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 176881.6 мянган төгрөгийн буюу 97.2 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөгө оны эхэнд 5392.2 мянган төгрөг, оны эцэст 6096.5 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцсийн өглөгийн ЗДТГазар 2196.9 мянган төгрөг, Соёлын төв 2633.2 мянган төгрөг эзэлж байна

### **Бараа материал**

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 81498.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 191906.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 179936.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 93468.6 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

### **Үндсэн хөрөнгө**

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 5150507.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 127361.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 19344.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 5258524.6 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 141260.1 мянган төгрөг үлдэх өртөг 2739954.2 мянган төгрөг байна

### **Тусгай зориулалтын сангууд**

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

#### **Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:**

“Орон нутгийн хөгжлийн сан”-д 2013 онд Төв Орон нутгийн хөгжлийн сангаас 83676.0 мянган төгрөгний санхүүжилт орсон, суманд уул уурхайн үйлдвэрлэл, хайгууль явуулж байгаа аж ахуйн байгууллагуудаас 18500.0 мянган төгрөгний хандив өгсөн, бүгд 102176.0 мянган төгрөгний орлого оржээ.

Сангаас аймгийн болон сумын баяр наадмын зардалд 10187.2 мянган төгрөг, сумын эмнэлэг, Соёлын төв, Цэцэрлэг, аймгийн Цэнгэлдэх хүрээлэн зэрэг газарт хөрөнгө оруулалтын ажилд 32337.4 мянган төгрөг, бүгд 42524.6 мянган төгрөгний зардал гаргажээ. 2014.01.01-нд санд 59651.4 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Сангаас худалдаж авсан бараа, материалаас 43 нэрийн 1094.6 мянган төгрөгний бараа, материал биет байдлаар үлдэгдэлтэй байгааг дансанд орлогод аваагүй байна.

Мөн сангаас авсан барилгын засварын материалаас 808.6 мянган төгрөгний материалын үлдэгдэлтэй байгааг дансанд тусгасан байна.

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29.1.3-т заасан эрх, үүрэг (29.1.3-т е/нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжид заасны дагуу санал өгөх; ж/газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх; н/нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах гэж заасан).

Уг эрх үүргийг хэрэгжүүлдэг сумын Засаг дарга нь сумынхаа нутагт ашигт малтмалын ашиглалт болон хайгуулийн ажил гүйцэтгэж байгаа болон орон нутгийн ашигт малтмалыг түшиглэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажил хийж байгаа хувийн өмчийн аж ахуйн байгууллагуудад аймгийн 90 жилийн ойн арга хэмжээнд хандив өгөхийг хүссэн албан бичиг / 2013.7.22-нд 214, 2013.7.18-нд 211 тоот, ... / илгээж, нийт 8 аж ахуйн байгууллагаас 18500.0 мянган төгрөгний хандив авсан нь Монгол улсын “**Нийтийн албанд**

**нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17.1-д** Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

**Мал хамгаалах сангийн талаар:**

Тус санд 2013.1.1-нд 5140.0 мянган төгрөгний өвс, сүрэлний үлдэгдэлтэй байснаас 456.0 мянган төгрөгний өвс, сүрэл борлуулж, 2014.1.1-нд 4684.0 мянган төгрөгний өвс, сүрэлний үлдэгдэлтэй байна.

Сангийн харилцах дансанд оны эхэнд 265.8 мянган төгрөгний үлдэгдэлтэй, 2013 онд өвс, тэжээл борлуулсаны орлогоор 456.0 мянган төгрөг орж, зардал гараагүй, оны эцэст 721.8 мянган төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Сүм хөгжүүлэх сангийн талаар:**

Тус санд оны эхэнд 64261.2 мянган төгрөгний үлдэгдэлтэй, зээлдэг нараас авах 95260.3 мянган төгрөгний зээл, хүүгийн авлагатай байсан байна. 2013 онд тус санд аймгаас 50000.0 мянган төгрөгний санхүүжилт, зээлдэгч нараас 71032.9 мянган төгрөг, Мянганы хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдсан худгийн эргэн төлөлтөөр 144.0 мянган төгрөг бүгд 121176.9 мянган төгрөгний орлого оржээ.

Сангаас 136500.0 мянган төгрөгний зээл олгож, авто машин худалдсан үнэ 5000.0 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт төлж, 24.3 мянган төгрөгний илүү төлөлт буцаан олгож, 611.0 мянган төгрөгний аж ахуйн зардал, бүгд 142135.3 мянган төгрөгний зардал гаргажээ. Оны эцэст 43302.8 мянган төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, зээлдэгч нараас авах 176881.6 мянган төгрөгний зээл, хүүгийн авлагатай байна. Үүнээс 3 иргэний 9153.1 мянган төгрөгний зээл хугацаа хэтэрсэн байна

2013 онд шинээр олгосон зээлийн хувийн хэргийг журамд заасны дагуу бүрдүүлжээ.

**ГХУССан**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сумын орон нутгийн төсвөөс 2075.7 мянган төгрөгний санхүүжилт олгогдож, уг арга хэмжээнд 1064.4 мянган төгрөгний зардал гаргажээ. ГХУС арга хэмжээний дансны оны эхний үлдэгдэл 420.0 мянган төгрөг, оны эцэст 1431.3 мянган төгрөг байна.

“Сумын Ахмадын сан” –г ГХУССангийн дансаар зарцуулдаг байна. Тус санд оны эхэнд 5051.5 мянган төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан. 2013 онд Сургуулиас 200.0 мянган төгрөг төвлөрүүлсэн, ахмадын арга хэмжээнд 1914.0 мянган төгрөгний зардал гаргаж, оны эцэст санд 3337.5 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Ахмадын сангаас ахмадуудад гаргасан зардлаас 510.0 мянган төгрөг нь хүлээн авалтын, 1404.0 мянган төгрөг нь чихэр, цай, ёотон зэргээр гарын бэлэг өгсөн зардал байна.

1 хүнд амьдралд нь тусламж үзүүлж 50.0 мянган төгрөг олгосноос өөр амьдралт нь тусласан зардал гаргаагүй байна.

**Байгаль хамгаалах сангийн талаар:**

Тус сангийн харилцах данс нь оны эхэнд 4881.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд аймгаас санхүүгийн дэмжлэг 12000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 648 тоот захирамжаар 175.0 мянган төгрөгийг биотехникийн арга хэмжээнд зориулан ирсэн, 2013.08.15-ний өдөр Урансайханаас торгуулийн төлбөрт 100.0 мянган төгрөг нийт 12275.0

мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж хог цэвэрлэгээний шатахууны зардалд 4073.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Шатахууныг олгохдоо сумын Засаг даргын захирамжийн дагуу зарцуулж няравын тайланг тамгын газрын нярав хийж тайлагнасан байна. Торгуулийн 100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийн 2014 оны 2-р сард залруулж орон нутгийн орлогот шилжүүлсэн байна.

### **Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:**

Тус сангийн харилцах данс нь оны эхэнд 26355.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 11 удаагийн шилжүүлгээр 2800.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн зарлагын гүйлгээ гараагүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

### **Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд**

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

### **Залруулагдаагүй алдаа**

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд 4080.5 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

### **Тайлбар мэдүүлгийн захидал**

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

### **Аудитын санал дүгнэлт**

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын газар

2014.03.24